



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар Б/10

Хэрлэн сум

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2, 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2024 оны “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 3, 4, 10, 11, 12 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай” 82 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон тул аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын цалинг 1 дүгээр хавсралтаар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагын дарга нарын цалинг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Шинэчилсэн цалинг тогтоолд заасны дагуу 2024 оны 4 дүгээр сарын 01-ээс тооцож, холбогдох нэмэгдлүүдийг хууль, журамд заасны дагуу олгохыг байгууллагын Нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА НАРЫН ШИНЭЧИЛСЭН ЦАЛИНГИЙН ЖАГСААЛТ**

№	Эцэг/эхийн болон өөрийн нэр	Албан тушаал	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Үндсэн цалин	Орон нутгийн нэмэгдэл
1.	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч	УТ	2310000	20
2.	Ж.Гантулга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	ТЗ-2	2171000	*



Аймгийн Засаг даргын 2024 оны дүгээр сарын 03-ны өдрийн дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРЫН ШИНЭЧИЛСЭН ЦАЛИНГИЙН ЖАГСААЛТ

№	Эцэг/эхийн болон өөрийн нэр	Албан тушаал	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Үндсэн цалин	Орон нутгийн нэмэгдэл
1.	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	ТЗ-4	1933000	20
2.	Г.Нэргүйбаатар	Биеийн тамир, спортын газрын дарга	ТЗ-4	1933000	20
3.	С.Мөнхцэцэг	Боловсрол шинжлэх ухааны газрын дарга	ТЗ-4	1933000	20
4.	Б.Сүнгээ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга	ТЗ-4	1933000	20
5.	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга	ТЗ-4	1933000	20
6.	Д.Пүрэвжав	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга	ТЗ-4	1933000	20
7.	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	ТЗ-4	1933000	20
8.	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга	ТЗ-4	1933000	20
9.	Т.Отгонтуяа	Нийтийн номын сангийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч	ТҮСБ-6	1621000	20
10.	Н.Нямсүрэн	Музейн захирал	ТҮСБ-6	1621000	20
11.	Д.Цогт-Эрдэнэ	Хан Хэнтий чуулгын дарга	ТҮСБ-7	1703000	20
12.	Ч.Ундармаа	Батширээт сум дундын ойн ангийн дарга	ТҮ-11	1621000	40
13.	Г.Даваажаргал	"Биндэр-Ой" сум дундын ойн ангийн дарга	ТҮ-11	1621000	40
14.	Г.Мөнх-Оргил	Хэнтий шинэс сум дундын ойн ангийн дарга	ТҮ-11	1621000	40